



2-р сарын Тайлан

ХҮҮХЭД ХАМГАЛАЛ, ХӨГЖЛИЙН ТӨВ



Тоон үзүүлэлт

2021.02.28

НИЙТ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ

10

Хүйс



Эмэгтэй

7



Эрэгтэй

3

Нас



1-5 нас

2



6-10 нас
6



11-13 нас
2

Тайлбар

Ид шидийн орон ХХХТ-н түр хамгаалах байранд 2 сарын 28-ны байдлаар 10 үйлчлүүлэгч хамгааллын үйлчилгээг авч байна. Үүний 7 эмэгтэй, 3 эрэгтэй. 1-5 насны 2 үйлчлүүлэгч, 6-10 насны 6 үйлчлүүлэгч, 11-13 насны 2 үйлчлүүлэгч байна.





Нэг охины маань дэвтэр
шоколад болсон байв.

Багш:

Дэвтэр нь яагаад шиколад болчихов?

Охин:

Шоколад идсэн юм чинь тэгэлгүй яадаг юм...



Адтай шүү энэ охицууд

Цагаан сараар хүүхдүүд маань



Ид шидийн орон төвийн Түр хамгаалах байрны хүүхдүүд маань өглөө эртээ босоод, цай хоолоо идээд, багш нар болон найзуудтайгаа золголтоо хийгээд, шагайгаар наадаж сайхан шинэлсэн.

Үндэсний хувцасаа өмсөөд, шагайгаар наадаад манай хүүхдүүдэд их л таалагдав.


Тоглоом дундуур нь хамгийн жаахан нь шагайг нь авч гүйгээд нилээн бужигнав Ид шидтэй ах эгч нартаа хүүхдүүдийнхээ сэтгэл хөдлөл, царианы хувирал, хоолойны баяр баясгаланг сонсгож, харуулмаар байдаг ч нууцлал, хүүхдийн эрх гэдгийг хамгийн сайнаар анхаарах ёстой байдаг тул ийм олон эможитой байгаа шүү .

Дохионы хэлний харилцааны анхан шатны сургалтанд хамрагдлаа



Basaid хүмүүнлэгийн байгууллагатай хамtran хэрэгжүүлж буй төслийн хүрээнд "Сонсголгүйн Боловсрол" ТББ-аас 25 цагийн Харилцааны анхан шатны сургалтыг Ид шидийн орон-1 төвийн нийт ажилчид амжилттай дүүргэн гэрчилгээгээ гардан авлаа. Сонсголын болон харааны бэрхшээлтэй иргэдэд тэгш боломж олгох тал дээр Лантуун дохио ТББ-аас олон чиглэлийн ажлуудыг хийж байна. Цаашид ч Ид шидийн орон-1 болон 2 төвдөө тулгуурлан олон талын төслүүдийг хэрэгжүүлэхээр хичээн ажиллах болно. Бидэнтэй хамtran ажилласан Сонсголгүйн Боловсрол ТББ-ын хамт олондоо талархъя. Цаашид илүү олон төсөл хөтөлбөрүүд дээр хамтрана гэдэгт итгэлтэй байна.

Тэгээн хайрын баяраар багшидаа зоршулан бэлдсэн хүүгийн бэлэг...



Тэгээн хайр гэж л
энэ байх даа.

ХӨЛ ХОРИОНЫ ҮЕЭР **ЗАГАСЧИЛЖ** ЦАГИЙГ ХӨГЖИЛТЭЙ ӨНГӨРӨӨЦГӨӨСӨН ШҮҮ.



Батшаа энэ загасны уурга
савлаад их хэцүү юм тэ.

Тэр чичрээд загасныхаа
аманд хийж чаддаггүй ээ...



Түр хамгаалах байрны үйлчлүүлэгч хүүхдүүд маань
СЭТГЭЛ ХӨДЛӨЛӨӨ ИЛЭРХИЙЛЭХ, ТАНИХ
чадварт суралцаж байна.



ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХӨГЖЛИЙН ТӨВ



Бидэнд маш олон төрлийн картууд байдаг шүү.
Ид шидтэй ах эгч та бүхнийхээ ачаар

**Ид шидийн орон ХХХТ-ийн
түр хамгаалах байрны
бяцхан үйлчлүүлэгч хүүхдүүд маань
хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд
бүтээлч байдлаар өдөр тутамдаа
хөгжиж байна.**



Түр хамгаалах байрны дэлгүүр маань 7 хоног бүр нээгддэг билээ. Үйлчлүүлэгч хүүхдүүдийн худалдан авах чадварыг сайжруулах, мөнгөн тэмдэгтүүдийг цээжлүүлэх, **санхүүгийн боловсрол олгох** зорилготой. Хүүхдүүд маань дэлгүүрийн бараанаасаа өөрсдийн хэрэгцээндээ тохируулан хичээлийн хэрэгсэл, гоёл чимэглэл, дотуур хувцас, ариун цэврийн хэрэгсэл зэргийг худалдан авдаг.

Азаа багш мөнгөн тэмдэгтийг чихрээр орлуулж тайлбарлаж байна. Бид энэхүү харилцан яриаг 1 цаг сонссон юм кк.



- **1 мянган төгрөг дээр 1 зуун төгрөг нэмж чамд өглөө.**
Чамд нийт хэдэн төгрөг байгаа вэ?
- **Гурван зуу...**
- **Найзаа толгой тархи нь сийрэг байна уу,**
багш нь чамд дахиад эхнээс нь тайлбарлаад өгье?
- **Сийрэг гэж юу гэсэн үг ийин...**



Төрсөн өдөр

Хөөрхөн бяцхан үйлчлүүлэгчдийнхээ төрсөн өдрийн арга хэмжээг үргэлж зохион байгуулдаг билээ.
Энэ орчлонд хүн болж мэндлэх их хувь заяа шүү дээ.
Өнгөрсөн хөл хорионы олон саруудад Ид шидийн орон 1 төвийн Түр хамгаалах байр нэг ч өдөр тасалдалгүй ажилласаар байгаа шүү




**Идшидийн орон XXXТ ТХБ-ны нийт ажилтнууд Улаан загалмай нийгэмлэгийн
анхны тусlamжийн сургалтанд амжилттай хамрагдлаа.**



Ид шидийн орон 1 тур хамгаалах байранд байгаа
бүх үйлчлүүлэгчид маань урьдчилан сэргийлэ
хяналтын үзлэгт тогтмол хамрагдаж байгаа.



11-16 насны эмэгтэй үйлчлүүлэгч нарт хувийн ариун
цэвэр сахих болон шилжилтийн насанд гардаг
физиологийн өөрчлөлт сэдэвтэй сургалт оров.



Түр хамгаалах байрны үйлчлүүлэгчдийнхээ дархлааг нэмэх,
эрүүл мэндийг дэмжих зорилгоор шаардулагатай аминдэм,
витаминуудыг тогтмол өгч байна.



Нийт үйлчлүүлэгч нарт хоол хүнсний эрүүл
хэрэглээ сэдэвтэй сургалт орж, хоол хүнсийг зөв
сонгож хэрэглэх, зөв хадгалах болон биед ямар хоол хүнс
хэрэгтэй, ямар хүнс зохимжгүй талаар ярилцав.



Сүүн шүдхэн шудний эмнэлэгтэй хамтран түр хамгаалах
байранд байрлан үйлчлүүлж буй үйлчлүүлэгчээс
1 удаагийн явалтаар 2 хүүхдийн шүд эрүүлжиж,
1 хүүхдийн шудний эмчилгээ үргэлжилж байна.





ИШАЭ-ИЙН НОМЫН САН

75 НОМ

танхимаар уншигдсан.

Хөл хорионы үетэй холбогдуулан гаднаас уншигч хүүхдүүд оруулахгүй байсан.
“Ид шидийн орон” XXX төвийн үйлчлүүлэгчид болон ажилчид гэрээр болон
танхимаар ном авч уншсан. Энэ сард нийтдээ 75 ширхэг ном уншигдсан.



**Өнгөрсөн 2 дугаар сард нийт 8 сурагчид 1-5 дугаар ангийн Монгол хэл,
Математикийн хичээлийн давтлага хичээлийг тогтмол орсон.
Сургалтын хугацаанд үйлчлүүлэгч хүүхдийг 3 түвшинд хуваан авч хичээлд хамруулсан.**

1-р түвшинд

1-р түвшинд нийт 2 сургач хамрагдсан
цагаан толгойн үсэг болон
1-100 дотор нэмж хасах аргад суралцсан.



2-р түвшинд


2-р түвшинд нийт 2 сургач хамрагдаж
цээжээр бичих, эх зохиох, өгүүлбэртэй
бодлого бодох, хүрд цээжлэх гэх зэрэг
олон сургалтад хамрагдсан.



3-р түвшинд

3-р түвшинд нийт 4-10 дугаар ангийн
4 сургач хамрагдаж, үржих хуваах арга,
зөв бичих дүрэм, тийн ялгал гэх мэт олон
сургалтанд мэн хамрагдсан.





Оригами

"Оригами" онлайн бичлэг үзүүлэн, цаасаар бэлгийн хайрцаг болон үзэгний сав хийж сурсан.



Монголчуудын үндэсний баяр болох "Цагаан сар"-тай холбогдуулан үндэсний шагайн наадгайн талаар мэдлэг олгон, шагай таах, морь уралдуулах, алаг мэлхий өрөх зэргээр шагайн наадгайгаар тоглосон. Бага насын сурагчид маань шагай орхин морь, хонь, тэмээ, ямаагаа нэрлэж сурсан шүү.

Нэгэн сурагчийн малгай нь газарт унасан байхаар нь "Малгайгаа аваарай. Малгайгаа дээдэлж байх хэрэгтэй. Чиний толгой гэсэн үг шүү дээ гэтэл "тэгвэл багшаа ороолт газар унасан байвал хүзүү нь наад унжсан байна гэсэн үг үү? Хэмээн асуулаа.



ЗАРДЛЫН ТАЙЛАН

ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ
Цэцэрлэгийн хүхдийн холны зардал
Цэцэрлэгийн хангамжийн зардал
Сургалт, судалгаа, хөгжүүлэтийн хэрэглэгдэхүүний зардал

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ
Хамгаалах байрны хүүхдийн холны зардал
Хамгаалах байрны хүүхдийн хувцас зардал
Хамгаалах байрны хүүхдийн ахуйн хэрэглэлийн зардал
Сэтгэл заслын үйлчилгээний зардал
Хүүхэд хамгааллын нийгэмшүүлэх үйлчилгээний зардал
Хүүхэд хамгааллын үйлчилгээний зруул мэнд эм хангамж зардал
Хүүхэд хамгааллын үйлчилгээний хангамж зардал/ үс замах анги цэвэрлгээ хуриитлал
Бичиг хэргийн зардал
Томилотын зардал
Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал

АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ
Цахилгаан
Бохир ус
Цэвэр ус
Хог тээвэр
Интернет
Утас ид шидийн орон
Утас хамгаалах байр

ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ
Цалингийн зардал /хамгаалах байр /
Цалингийн зардал /Ид шидийн орон нэг /
Цалингийн хуриитлалын зардал
НДШ-ийн зардал /нийт цалин/

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ
Ажилчдын холны зардал
Маркетингийн зардал
Ногоон багцууламжийн арчилгааны зардал
Цэвэрлэгээ, ариутгалын зардал
Барилгын засварын зардал
Тоног төхөөрөмжийн засварын зардал
Шатахууны зардал
Тээврийн зардал
Шатахууны зардал ид шидийг орон нэг
Тээврийн зардал ид шидийн орон нэг
Томилотын зардал ид шидийн орон нэг
Бичиг хэргийн зардал ид шидийн орон нэг
Сургалтын зардал
Uniform, унэмлэх гм
Татварын зардал Үл хадлех, газар
Давтгальын зардал

НЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ
Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал
Бусад зардал \нотариат, орчуулга, карго\

ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ - 1650%

14,396,140 ₮

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗАРДАЛ - 284%

2,475,700 ₮

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ - 241%

2,100,177 ₮

АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ
11,2%

97,600 ₮

АНУ ИШАЭГЧ ХӨТӨЛБӨРӨӨС
ХАНДИВЫН ОРЛОГО

872,258₮